



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 09 өдөр

Дугаар А/353

Улаанбаатар хот


**Хөрөнгө хүлээн авах ажлын
хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2019 оны А/291 дүгээр захирамж, Багануур дүүргийн Засаг даргын “Үнэлгээний хороо байгуулах тухай” 2019 оны А/278 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Сэцфлорис” ХХК-тай байгуулсан “Багануур дүүргийн нийгмийн салбарын байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах бараа нийлүүлэх” НХААГ/201905437 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдэж буй хөрөнгийг хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.


2. “Багануур дүүргийн нийгмийн салбарын байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмж” /LED дэлгэц/-ийг тендерийн баримт бичиг, техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авах ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг /Д.Рэнцэнбямба/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 10 дугаар сарын
09 өдрийн 438 дугаар тушаалын хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Рэнцэнбямба	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын орлогч дарга
Гишүүд:	Э.Алтангэрэл	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтсийн сургалт, орон нутгийн өмч хариуцсан мэргэжилтэн
	Б.Мөнхчимэг	Багануур дүүргийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Д.Ганбаяр	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн ашиглалт, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Б.Мөнгөнхүү	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн